

МОНГОЛ ЗӨВЛӨЛТИЙН 1921 ОНЫ ГЭРЭЭ: ТҮҮХ БА БАРИМТ

О.БАТСАЙХАН

*Түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D)
ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан*

Хураангуй: 1921 оны 11 дүгээр сарын 5-нд Москва хотноо байгуулсан Зөвлөлт Орос Улс Монгол Ард Улсын Найрамдлын гэрээний чухам үнэн байдлыг тодруулж, уг гэрээний учир холбогдол, Монголын түүхэнд оруулсан түүхэн үүргийг үнэлж дүгнэлт өгөх болно. Монгол Улс, ОХУ-ын архивын сурвалжид тулгуурлан 1921 оны Монгол - Зөвлөлт Оросын гэрээний учир холбогдлыг шинээр авч үзэж, эл гэрээний талаар санал солилцохыг хүсэж буй юм. Тэрхүү хэлэлцээрт оролцсон Монголын төлөөлөгчид уг гэрээг хэрхэн ойлгож байсан, мөн Зөвлөлтийн төлөөлөгчдийн байр суурь ямар байсан зэрэг асуудлуудыг тодруулж тавих болно.

Түлхүүр үгс: 1921 оны Монгол-Зөвлөлтийн гэрээ, Монголын түүх, С.Данзан, Д.Сүхбаатар, Г.Чичерин, Б.Шумяцкий, С.Духовский, Б.Гец

Гэрээ байгуулахын өмнөх нөхцөл байдал

Монгол Ардын Засгийн газраас Зөвлөлт Орос улсад 1921 оны 7 дугаар сарын 12-ны өдөр хандаж, Улаан армийн ангийг Монголд түр үлдээхийг “хүссэний” дагуу Зөвлөлтийн Улаан армийн тодорхой хэсэг Монголд 1925 он хүртэл байрлаж байв. (Монгол Ардын Хувьсгалт Намын товч түүх 1-5 дугаар бүлэг 1964: 69) Энэ нь Монголын аюулгүй байдалтай холбоотой хэдий ч гол асуудал Монгол нутагт байрлаж байсан цагаантнуудыг бут цохиход чиглэж байлаа. Тиймээс ч Зөвлөлтийн Засгийн газраас “нийтийн дайсан цагаантныг бут цохих хэрэгт Монгол Ардын цэрэг болон түүний удирдах зүтгэлтэн нарын байгуулсан гавьяаг өндрөөр үнэлж, 1922 онд Ардын цэргийн жанжин Д.Сүхбаатар, Х.Чойбалсан, Хатанбаатар Магсаржав нарыг байлдааны улаан тугийн одонгоор шагнажээ”. (Монгол Ардын Хувьсгалт Намын товч түүх 1964: 71)

1964 онд бичсэн МАХН-ын түүхэнд бичихдээ: “Нийтийн дайсны эсрэг хамтарсан тэмцлийн гал дунд Монгол-Зөвлөлтийн ард түмний ах дүүгийн гүн зузаан найрамдал, дайчин холбоо бүрэлдэн тогтжээ. Зөвлөлтийн ард түмэнтэй тогтоосон энэ бат найрамдал холбоог бүхий л талаар зузаатган бэхжүүлэх явдал

Ардын нам, засгийн гадаад бодлогын үндсэн гол шугам болов” (1964: 71) хэмээн тэмдэглэсэн нь эл үеэс хойших Монгол ард улсын гадаад харилцааны ерөнхий чиглэлийг тодорхойлсон хэрэг юм. Эл үеэс хойших Монгол Улсын гадаад харилцаа нэг цонхтой болсон юм. Бүр 1921 оны 7 дугаар сарын 10-нд Монгол ардын засгийн газраас Зөвлөлт Орос улсын Засгийн газарт явуулсан бичигтээ засгийн эрхийг Богдын Засгийн газраас авсанаа яаравчлан мэдэгдэж, “хоёр улсын найрамдалт харилцааг хойшид улам зузаатгахыг эрмэлзэж байгаагаа” илэрхийлсэн байдаг.

Ардын Засгийн газраас 1921 оны 9 дүгээр сард батлан гаргаж, улмаар Ардын түр цагийн хурлаар сайшаасан “Монгол Улсыг тусгаар тогтносон тухай гадаадын олон улсуудад тунхагласан бичиг”-т: “Одоо манай ардын засгийн газраас ер Дундад улстай өшөө хорсолыг агуулан байлдах дайлах хэргийг явуулах саналгүй боловч Хятадын сюзеренитетийг дахин хүлээж хэрхэвч чадахгүй, гагцхүү одоогийн байгуулсан ардын эрхтэй хэмжээт засгийг өөрөө эзэрхэн явуулж, Дундад, Монгол эртхэнээс харилцан найрамдаж, худалдаа арилжааг нэвтрүүлэн Дундад, Монголын хүн иргэнийг тус тусдаа энт түвшиний улиралд хандуулахыг гүнээ эрмэлзэх бүхий” (МАХН-ын товч түүх 1964: 74) хэмээн Монголоос Хятадтай харилцах бодлогоо тодорхойлсон байна. Монгол ард улсаас Хятад улстай харилцахдаа хоёр улсын тусгаар тогтнол, эрх тэгш байдлыг харилцан хүндэтгэх, тус тусын дотоод хэрэгт үл оролцох үндсэн дээр найрсаг харилцаа, хамтын ажиллагаа тогтоон хөгжүүлэх эрмэлзэлтэйгээ ийнхүү илэрхийлсэн байна.

Монгол Улсын Засгийн газраас 1910-аад онд баримталж байсны нэгэн адилаар дэлхийн бусад улстай ч харилцан хүндэтгэх тэгш эрхийн зарчим дээр тулгуурлан дипломатын болон эдийн засгийн талаар харилцаа тогтоож, хамтран ажиллах бодлого баримтлах хүсэлтэй байлаа. Иймээс Монгол Ардын засгийн газар 1921 оны 9 дүгээр сарын 12-нд Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газарт нот явуулж, хоёр улсын хооронд дипломат ба худалдааны тэгш харилцаа тогтоох санал тавьжээ. Харин Америкийн Засгийн газар Монгол Ард Улсын Засгийн газрыг хүлээн аваагүй бөгөөд учир нь Монголыг Хятадын нэг хэсэг хэмээн үзэж байсан юм.

Зөвлөлт засаг ч гэсэн чухамдаа бол Монголын Ардын Засгийн газартай хэлэлцээ хийхэд дуртай байсангүй. Учир нь эл үед Зөвлөлтийн Гадаад хэргийн яамны түшмэл Л.М.Карахан, А.Иоффе зэрэг хүмүүс Зөвлөлт, Хятадын хооронд хэвийн харилцаа тогтооход Монголын асуудал саад болж буй хэмээн үзэж, Хятад, Монголын хооронд зуучлагчийн үүрэг гүйцэтгэхийг оролдож байсан юм.

Энэ талаар Монголоос 1921 оны 9 дүгээр сарын 10-нд Б.З.Шумяцкий Г.В.Чичеринд бичсэн захидалдаа: “ерөөсөө бие цогцос, эд материалын хувьд сул дорой Монгол орон Хятадын, Японы ч юмуу өөр ямар нэгэн улс төрийн хүчирхэг бүлэглэлийн олз болоход хүрнэ. Ийм ч учраас Монгол гэдэг хөөрүү сэтгэлтэй, улс төрийн хувьд нялх хүүхдийг “тусгаар тогтнол” гэдэг хорхой хүрмээр ч гэсэн аюул осол ихтэй нутаг газар руу хал бал ихтэй аялал хийхэд ямар ч гэсэн бид түлхэх ёсгүй билээ” (Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт 1920-1932. 2002: 101) гээд “хамгийн гол нь бид манай Орос, Хятадын харилцааг зохицуулах хэрэгтэй

байна” (Мөн тэнд 102) хэмээжээ. Өөрөөр хэлбэл, Монголд бүрэн тусгаар тогтнол олгохгүйгээр Монголын асуудлыг Зөвлөлт Хятадын харилцааны нэг түлхүүр болгох бодлого баримтална гэсэн санаа юм.

Зөвлөлт Засгийн газар Хятадтай харилцаагаа хэвийн болгохын тулд Монголын асуудалд хурдан шуурхай хандах шаардлагатай болсон нь Нийслэл Хүрээнд ирсэн АНУ-ын консул С.Сокобины айлчлалаас үүдэлтэй байна. 1921 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр Б.Шумяцкий Г.Чичеринд маш нууц цахилгаан мэдээ илгээж, түүндээ Америкийн консул С.Сокобин Нийслэл Хүрээнд ирээд сар гаруйн турш Монгол Ардын Хувьсгалт Засгийн газрыг Зөвлөлт орноос хөндийрүүлэх, мөн манай нөлөөг арилгах зорилгоор ноёд лам нарыг нягтруулахыг чармайж байна”, “Америкийн консул Богд гэгээнд нөлөөлж, түүгээр дамжуулан Монгол ардын хувьсгалт засгийн газарт чухамхүү америкчууд өөрсдөө тулгуурлах гэсэн хар шар феодалын бүрэлдэхүүн бүхий олон нийтийн зүтгэлтэн нарын зөвлөгөөн гэгчийг хуралдуулах асуудлыг тулгасан байв” хэмээн бичсэн байна. (Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт 1920-1932. 2002: 104)

Америкийн Нэгдсэн Улсаас Дундад Иргэн Улсын Хаалган хотод сууж байсан консул С.Сокобин 1921 оны 8 дугаар сарын 18-наас 9 дүгээр сарын 14-нийг хүртэл Монгол Улсын Нийслэл Хүрээнд хүрэлцэн ирж, Монголын төр, засгийн удирдагч нар лугаа уулзалт хийжээ. Тухайлбал, Ерөнхий сайд Д.Бодоо Америкийн консул С.Сокобинтой уулзаж, Монгол, Америкийн хооронд харилцаа тогтоож, хамтран ажиллах санал дэвшүүлэн Америкийн Засгийн газарт хандсан захидал гардуулсан байдаг билээ. Монгол Улсын Ерөнхий сайд Д.Бодоогоос Америкийн Засгийн газарт хандсан захидалд өгүүлэхдээ: “эртхэн гэрээ байгуулан, элчин сайд суулгаж, худалдаа арилжааг улмаар бадруулан хоёр этгээдийн ашиг тусыг хөгүүлэх” (Болд 2008: 114) -ийг хүссэн байна.

Монгол Улсын Ерөнхий сайд Д.Бодоогийн илгээсэн захидалд АНУ-ын талаас албан ёсоор хариу өгсөнгүй. Гиймээс Бодоо сайд Андерсен Мэйр компанийн төлөөлөгчөөр дамжуулан Америкийн консул С.Сокобиныг дахин Нийслэл Хүрээнд урьж, Монгол –Америкийн хооронд худалдааны хэлэлцээр байгуулах хүсэлтэй байгаагаа уламжилсан хэдий ч амжилт олоогүй юм.

Нийслэл Хүрээнд байхдаа Б.Шумяцкий Ерөнхий сайд бөгөөд Гадаад яамны сайд Бодоогийн нэрээр ЗСБНХОУ-ын Гадаад хэргийн ардын комиссариатад Хятадтай харилцахад зуучилж өгөхийг хүссэн нот бичиг 1921 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр илгээсэн байна.

Энэ бүхний үр дүнд ЗСБНХОУ-ын Ардын комиссар нарын зөвлөлийн дарга В.Ленин 1921 оны 10 дугаар сарын 18-нд Монгол, Хятадын хоорондын харилцааг зохицуулахын тулд БНХУ-ын Засгийн газартай хэлэлцээ хийх ЗСБНХОУ-ын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Улсын засгийн газрын дэргэдэх өөрийн тусгай төлөөлөгчдийн газрын Онц бүрэн эрхт төлөөлөгч Александр Константинович Пайкест Монголын ардын хувьсгалт Засгийн газраас ЗСБНХОУ-ын Засгийн газарт хандан хүсэлт тавьсны дагуу Монгол, Хятадын хоорондын харилцааг зохицуулахын тулд Бүгд Найрамдах Хятад Улсын Засгийн газартай

хэлэлцээ хийхийг даалгаж, бүрэн эрх олгосон байна. (Монголын тухай БХК(б) Н-ын баримт бичигт 1920-1932. 2002: 105)

Монгол Зөвлөлт Оросын хооронд гэрээ байгуулах үйл явц

Нийслэл Хүрээнд ирсэн Б.Шумяцкийн санлаар Зөвлөлт Орос Улс Монгол Улсын хооронд гэрээ байгуулах асуудал тавигдсан байна. Тиймээс Монголын асуудлыг Зөвлөлтийн Гадаад харилцааны яам болон Коминтерний Гүйцэтгэх товчооны хамтарсан тусгай комиссын хурлаар 1921 оны 10 дугаар сард хэд хэдэн удаа хэлэлцжээ. Эл хуралд Г.Чичерин Зөвлөлт Орос Монголын хооронд гэрээ байгуулах нь зүйтэй гэсэн Б.Шумяцкийн саналыг дэмжиж, энэ нь Зөвлөлт Орос оронд геополитикийн хувьд ашигтай хэмээн үзэж байсан байна. Тиймээс Г.Чичерин В.И.Ленинд 1921 оны 10 дугаар сарын 18-ны өдөр бичсэн захидалдаа: “Монголын хувьсгалт засаг бол бидний гарт байгаа маш чухал “хөзөр” юм. Хувьсгалт засгийг Монголд бий болгосон нь Номхон далайгаас Каспийн тэнгис хүртэлх уудам нутагт хувьсгалын эсрэг фронт тогтоох зорилготой Японы төлөвлөгөөг эвдэж хаясан зүйл болсон юм. Ах дүүгийн найрамдалт Монгол нь манай өмнөд хилийг хамгаалах нь бидэнд аюулгүй байдлаа бэхжүүлэхэд тун чухал зүйл болох юм” (Лузянин 2015: 117) хэмээжээ. Эл үед Зөвлөлт Орос улс Японтой Алс Дорнодын төлөө дайтаж байсан болохоор Японы хүчин зүйлс Монголтой гэрээ байгуулахад тодорхой нөлөө үзүүлсэн хэрэг юм.

1921 оны 9 дүгээр сард Б.З.Шумяцкий Нийслэл Хүрээнд айлчилсаны үр дүнд Монголоос Засгийн газрын гишүүн, Сангийн яамны тэргүүн сайд Солийн Данзан тэргүүтэй төлөөлөгчид Москва явсан байна. Зөвлөлт Засгийн газарт хандан зуучлагч болох хүсэлт тавьсан Ерөнхий сайд бөгөөд Гадаад яамны тэргүүн сайд Д.Бодоо биш Сангийн сайд С.Данзан байв. Баримт бичгүүдээс үзвэл Монголын Засгийн газрын төлөөлөгчид худалдааны хэлэлцээ хийх зорилго, санаатай явсан ч байж магадгүй байдаг.

Ингээд Монголын Засгийн газраас Зөвлөлт Орос улстай хэлэлцээр хийхээр С.Данзан тэргүүтэй Засгийн газрын төлөөлөгчид 1921 оны 10 дугаар сард очжээ. Монголын Засгийн газрын төлөөлөгчдийн тэргүүнээр МАН-ын дарга, Сангийн яамны тэргүүн сайд С.Данзан, бүрэлдэхүүнд нь Гадаад яамны эрхэлсэн түшмэл Б.Цэрэндорж, Цэргийн яамны тэргүүн сайд Д.Сүхбаатар, Богд хааны бие төлөөлөгч Жонон ван Ширнэндамдин, орчуулагч Батхаан нар багтсан байв.

Зөвлөлтийн талаас ЗСБНХОУ-ын Гадаад хэргийн ардын комиссариатын Дорнодахины хэлтсийн дарга С.И.Духовский, тус хэлтсийн ажилтан Б.В.Гец нар оролцжээ.

Монголын талаас Зөвлөлтийн засгийн газартай байгуулах гэрээний төсөл авч очоогүй байна. Монгол Улсын Засгийн газрын хурлаар гэрээний төсөл хэлэлцээгүй байх бөгөөд Монголын талын гэрээний төсөл монгол хэлээр байхгүй юм.

1921 оны 10 дугаар сарын 26-ны өдөр болсон Монгол Зөвлөлтийн Засгийн

газрын төлөөлөгчдийн хэлэлцээрийн анхны хуралдаанд Монголын Ардын Засгийн газрын төлөөлөгчдийн дарга С.Данзан Зөвлөлт Засгийн газарт хандсан 8 зүйл бүхий меморандум бичгийг өгсөн байна. Эл бичиг орос хэлээр Данзангийн гарын үсэгтэй юм. Уг меморандумд бичсэн 8 зүйлийн тухай тэр бүр хэлж ярьдаггүй байсаар саяхан болсон бөгөөд ОХУ-ын Гадаад явдлын яамны архиваас ил болгосноор бид мэдэх болсон юм.

Үүний нэгдүгээрт, ЗСБНХОУ-ыг Хятад Монголын хэлэлцээ хийхэд зуучилж өгөхийг хүссэн байна. Өөрөөр хэлбэл Ерөнхий сайд бөгөөд Гадаад яамны сайд Бодоогийн ирүүлсэн нот бичгийг агуулгатай адил хүсэлт байна.

Хоёрдугаарт, 1912 оны Монгол Оросын гэрээг дурьдаж, худалдааны хувьд ашиггүй гэрээ тул хүчингүй болгохыг хүссэн. Улмаар худалдааны шинэ гэрээ байгуулахыг хүсчээ.

Гуравт, Тагна Урианхайн хязгаарыг Монголын салшгүй хэсэг гэж итгэдэг, яс махны холбоо сүлбээтэй монгол, урианхай нарын улс төрийн нэгдэл нягтрал бол Монголын хязгаарын Тагна Урианхайн нутгийн энх амгалан, аз жаргалтай байхын баталгаа гэж үзэж байна гэсэн байна.

Дөрөвт, Буриадын асуудал тавьсан байна. Монголын Ардын Засгийн газар буриад монгол иргэдийн зарим хэсгийг Халхын нутагт шилжин ирэх асуудлыг аятай сайхан утгаар шийдвэрлэхийг хүсэн эрмэлзэж байна гэсэн байна.

Тавт, Орос Монголын 1913-14 оны хэлэлцээр ёсоор байгуулсан Ховд - Кош Агач, Монда – Улиастайн цахилгаан мэдээний шугамыг тоног төхөөрөмжийн хамт Монголын ардын хувьсгалт засгийн газарт үнэ төлбөргүй шилжүүлэн өгөхийг хүссэн байна.

Зургаад, Монгол Орос хоёр улсын хооронд шуудан харилцаа, илгээмж харилцан явуулж байх хэрэгтэй болох учир энэ талаар хэлэлцээр байгуулах санал тавьсан байна.

Долоод, Шинээр эмхлэн байгуулж буй Ардын хувьсгалт арми болон улсын хил хязгаарыг сахин хамгаалж байгаа улаан цэргийн ангиудад ноднин жил өгнө гэж амалсан төрөл бүрийн зэр зэвсгээ бүрэн өгөхийг хүсчээ.

Наймд, Санхүүгийн бэрхшээл байгаа тул манай ард түмэнд хөрөнгө мөнгө туслахаар амалсны зарим хэсгийг манай Засгийн газар нэгэнт авсан бөгөөд үлдсэн хэсгийг Зөвлөлт Засгийн газар энэ удаа бидэнд өгөхийг хүсчээ. (Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт 1920-1932. 2002: 111-112)

Данзангийн гарын үсэг бүхий эл меморандумын хариуг 1921 оны 10 дугаар сарын 29-нд өгсөн байна. Энэхүү хариу тунхаглалдаа Зөвлөлтийн Засгийн газар Орос, Монгол хоёр улсын эдийн засгийн харилцааг зохицуулахад хамаатай асуудлыг энэхүү хэлэлцээний явцад аль аль талдаа хамгийн аятай сайхнаар зохицуулна гэж итгэж байна. Урианхайн асуудлаар Монголын төлөөлөгчдийн тавьсан санал нь Оросын хөдөлмөрчин түмний энх тайван хүсэл эрмэлзэлд тохирч байгааг Оросын төлөөлөгчид баяртайгаар мэдэгдэж байна гэжээ. Мөн Орос улсын харьяанд байгаа буриад монголчуудад тэднийг өөрснөө хүсвэл Монголын нутагт чөлөөтэй шилжин суух бололцоо олгохоо илэрхийлжээ. Шуудан цахилгаан

мэдээний газрын барилга, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй олгох замаар Монголд туслахаа илэрхийлсэн байна. (Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт 1920-1932. 2002: 114)

Зөвлөлтийн тал гэрээний төсөлдөө Монголын байдлыг “Ирээдүйн холбооны Хятад ард улсын бүрэлдэхүүнд автономит эрхтэйгээр багтан орно” гэж тодорхойлсон байжээ. Энэхүү томьёоллыг Монголчууд хүлээн аваагүй тул Зөвлөлтийн талаас “эрх чөлөөт Монгол улс” гэсэн томьёоллыг хэрэглэх болсон байна. Харин “Эрх чөлөөт Монгол улс” гэсэн томьёоллыг Данзан болон бусад төлөөлөгчид Зөвлөлтийн удирдлага Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх чиг шугамтай нь нийцсэн зүйл гэж ойлгосон байна. Хэлэлцээрийн явцад Урианхайн хязгаар болон Цагаан хааны Оросын концессийн асуудал сөхөгджээ. Данзан 1920 оны намар Монголын төлөөлөгч нарт хандаж ГХАК-ын зүгээс хийсэн мэдэгдлийг Зөвлөлт Оросын талд сануулсан байна. Энэ нь Зөвлөлт Засгийн газар хуучин хаант засгийн аливаа концессоос бүрэн татгалзах тухай мэдэгдэл байв. Урианхайн асуудлыг хэлэлцээрт тусгахдаа: Энэ хязгаар нутаг нь Монгол ардын засгийн удирдлага дор байж тус улсын бүрэлдэхүүнд багтах болно гэдэг томьёоллыг Данзан санал болгов. 1921 оны 9 дүгээр сарын 9-нд Г.Чичеринээс Урианхайн ард түмэнд илгээсэн ноот бичигт: “Зөвлөлт Орос улс энэ хязгаарыг өөрийн нутаг гэж үзэхгүй байна. Түүний өөртөө засан тохинох эрхийг “Монголын чөлөөлөх хөдөлгөөнтэй” холбон авч үзэх болно” хэмээсэн байдаг. Энэхүү бүрэн бус далд утгатай томьёоллын ард тодорхой байдал нуугдаж байлаа. Өөрөөр хэлбэл Монголд Туваг нэгтгэх асуудлыг авч ярих цаг нь болоогүй гэж үзэж байв. Учир нь Монголын олон улсын харилцааны түвшинд эзлэх байр суурь тодорхойгүй хэвээр байв. Нөгөө талаар Монгол болон Туваг Хятадын засаг захиргаанд уусан нэгтгэх аюул оршсоор байлаа. Урианхай болон концессийн асуудлаас маргаан дэгдэж, бүр хэлэлцээр тасалдах дээрээ тулсан байна. Гурван хоногийн турш удтал хэлэлцээ хийсний үр дүнд гэрээ байгуулагджээ. Саяхан болтол бид Зөвлөлт Монголын гэрээ байгуулахад ямар ч саад тотгор байгаагүй хэмээн үзэж байлаа.

Ингээд 1921 оны 11 дүгээр сарын 5 буюу Монгол тооллоор Олноо өргөгдсөний 11 оны намрын адаг сар буюу 10 дахь сарын шинийн 6-ны өдөр “Монгол, Оросын хооронд найрамдлын барилдлагааг байгуулах тухай Монголын Ардын Засгийн Газар ба Зөвлөлийн Засагт Орос Улсын Засгийн Газрын хэлэлцэн тогтоосон гэрээ бичиг” буюу бидний нэрлэж хэвшсэнээр бол “Монгол Улс, Орос Улсын хооронд найрамдалт харилцаа тогтоох тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурсан юм.

Гэрээ нь бүтцийн хувьд ерөнхий зүйл болоод 13 бүлгээс бүтжээ. Харилцан буулт хийсэн олон салаа утгатай гэрээ болсон юм. Харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд Монголын олон улсын статусыг тодорхойлоогүй орхигдуулсан юм. Мөн Хятадтай харилцах асуудлыг оруулаагүй байна. Түүнчлэн Урианхайн хязгаарын асуудлыг орхигдуулжээ. Концессийн тухай асуудлыг 1921 оны 11 дүгээр сарын 5-ны гэрээний “нэмэлт протокол” маягаар оруулжээ. Үүнд Зөвлөлт Орос

улс Оросын хуучин концессийг шинэ эзэмшигчдэд шилжүүлэх үедээ “гуравдагч талын эрх ашгийг” хүртэх болно гэжээ. Мөн Москвад Монголын үндэсний мөнгөн тэмдэгт хэвлэх, Монгол ардын засгийн хэрэгцээнд зориулж сая рублийн зээлийг цэвэр цагаан мөнгөөр олгох тухай нууц хэлэлцээрт мөн гарын үсэг зуржээ.

Энэхүү гэрээний нэмэлт хоёр протокол, тухайлбал Хаант засгийн үед байгуулсан концесс, онц эрхийг Зөвлөлт Орос Улсын засгийн газар цуцалсан тухай, Шүүх таслах асуудлаар хамтран ажиллах тухай протоколд мөн өдөр төлөөлөгчид гарын үсэг зурсан байна.

1921 оны 11 дүгээр сарын 24-нд ЗСБНХОУ-ын Засгийн газраас Монголын Засгийн газарт нэг сая рублийн зээл олгох тухай бас нэгэн протоколд төлөөлөгчид гарын үсэг зурсан байна.

1921 оны 11 дүгээр сарын 5-нд Москвад болсон Зөвлөлт-Монголын хэлэлцээрийн үед Монголын тал Оросын газар нутагт суурьшсан буриадуудыг Монгол нутагт ирж амьдрах хүсэлт гаргасан тохиолдолд тэдэнд саад учруулахгүй байхыг Зөвлөлт засгийн газраас хүссэн байна. Үүний хариуд Зөвлөлтийн тал Монголын энэ хүсэлтийг хүлээж авсан ажээ. Зөвлөлт Оросоос Монгол болон Баргад нүүдэллэн суурьших буриадуудын тоо асар их болж энэ нь улс төрийн өнгө аястай байв. Тухайлбал, 1922 он болон 1923 оны эхэн гэхэд Буриадаас Монголд 20000 гэр бүл шилжин суурьшжээ. 1923 оны 3 дугаар сарын 3-нд Монголын ардын засгийн ГЯЯ-наас Монголд суугаа Зөвлөлтийн элчин төлөөлөгч Юдинд илгээлт явуулж, 1921 оны 11 дүгээр сарын 5-ны Москвагийн хэлэлцээрийн дагуу нүүн ирж буй буриадуудыг харьяалалдаа багтаан авч байгаа талаар мэдээлсэн байна. Үүний хариуд Зөвлөлтийн төлөөлөгч 1923 оны 3 дугаар сарын 20-нд Монголын ГЯЯ-нд мэдэгдэхдээ “Буриадуудын шилжин суурьшиж байгаа явдал нь олон түмнийг хамарсан үйл явц болсон бөгөөд энэ асуудал нээлттэй хэвээр үлдэх юм” гэсэн тодорхой бус хариулт өгчээ. Ингэснээр Зөвлөлтийн тал 1921 оны 11 дүгээр сарын 5-нд байгуулсан хоёр талын гэрээний дагуу буриадын шилжин суурьшигчдын асуудлаар хүлээсэн байр сууриндаа тууштай зогсохгүй нь илэрхий болсон байна.

Буриадуудын ийнхүү Монголд нүүдэллэн суурьших болсон шалтгаан нь тусгаар тогтнол, төр улсаа сэргээж буй Монголын хүчин зүйл байлаа. Үүнийгээ ч Зөвлөлт Засгийн эрх баригчдад нууж хаалгүй илэрхийлж байсан байдаг. Тухайлбал, 1923 оны 3 дугаар сарын 1-нд БХК(б)Н-ын Төв Хороонд хандаж Ербанов, Амагаев нараас бичсэн захидалд дурдахдаа: “овог аймгийн болоод шашин шүтлэгийн нэг үндэс бүхий монголчуудтай буриадууд хэл амаа ололцох нь тун амархан бөгөөд ингэснээр хөрш Монголд Зөвлөлтийн нөлөөг хэрэгжүүлэхэд буриадууд чухал үүрэг гүйцэтгэх болно. Түүнчлэн Монгол бол манай өмнөд Сибирийн хилийг хамгаалах найрамдалт завсарын улс болохыг анхаарах хэрэгтэй. Мөн Монголын Засгийн газрын төв удирдах байгууллагуудад Коминтерн болоод Гадаад Хэргийн Ардын Комиссариатын удирдлаганд байгаа буриадууд олон тоогоор ажиллаж байна. Үүнээс гадна Алс Дорнодод Японы империалистуудын эсрэг хувьсгалт нууц ажиллагаа явуулах шаардлага гарвал Японы нөлөөнд байгаа Өвөр Монголын газар нутаг дээр ухуулан сурталчлах

ажлыг буриадуудын хүчээр хийх боломж байгаа юм”. (Лузьянин 2015: 122) Мөн Ардын комиссариудын Зөвлөлийн гүйцэтгэх товчоонд илгээсэн өөр нэгэн бичигт дурдахдаа “Нэгдсэн Буриадын Бүгд Найрамдах Улсыг үүсгэн байгуулж улмаар монголчууд болон түвдүүдтэй “улс төрийн холбоо” тогтоож ингэснээр Зөвлөлтийн засаглалын давуу талыг Монгол-Түвдийн олон түмэнд ойлгуулах бололцоотой болох юм. Энэ нь Зөвлөлтийн гадаад бодлогыг Алс дорнодод бэхжүүлэх чухал ач холбогдолтой зүйл болох юм” гэжээ. Зөвлөлтийн удирдлага буриадуудын энэхүү санаачилгыг хөндий хүлээн авсан байна. 1923 оны 1 сарын 10-нд Гадаад Хэргийн Ардын комиссариатын газраас гаргасан дүгнэлтэнд дурдахдаа “Автономит Бүгд Найрамдах улс байгуулах явдал нь Оросын буриадуудтай гарал нэгтэй Алс дорнодын ард түмэнд соёлын нөлөө үзүүлэх гол үүрэгтэй юм” (Лузьянин 2015: 123) гэсэн бол Оросын коммунист намын Алс Дорнодын болон Сибирийн товчооны зүгээс иймэрхүү нэгдсэн Бүгд Найрамдах улс байгуулахын эсрэг байр суурьтайгаа илэрхийлсэн байна. Тэд иймэрхүү үйлдэл нь буриадын удирдлагын зүгээс “Панмонгол үндэсний үзлийг сэргээх” гэсэн буруу зүйл хэмээн үзэж байв. Мөн Коминтерний зарим удирдагчид ч буриадуудын зүгээс Монголын улс төрийн үйл ажиллагаанд хэт оролцохын эсрэг байр суурьтай байсан юм. Ялангуяа Өвөр Монголд бие даасан үйл ажиллагаа явуулахыг таашаахгүй байсан болно. Монгол Ардын Нам, Засгийн газраас Туваг Монголын нэг хэсэг хэмээн үзэж, 1923 онд Тувагийн Засгийн газарт хандан Монголд нэгдэх саналыг тавьсан боловч тэднээс татгалзсан хариу авсан юм.

Угсаа гарал нэгтэй монгол овогтон нийлж нэгдэх нь панмонгол үзэл сэргэх аюултай төдийгүй Оросын үндэсний ашиг сонирхолд харшилна хэмээн үзэж байсан учраас Зөвлөлт Оросын удирдагчид буриадуудын Монгол руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг таашаагаагүй бөгөөд энэ нь тодорхой хугацааны дараа ихээхэн хор хөнөөл дагуулсаныг түүх илтгэнэ.

Монголд тогтоож байсан хувьсгалт дэглэм, Зөвлөлтийн хяналт, шахалтын улмаас Ардын Засгийн газраас хятадуудыг шахан зайлуулах бодлого баримталсан билээ. 1922 оны 12 дугаар сард Засгийн газраас “тодорхой ажил эрхлээгүй бүх хятадуудыг Монголоос хөөх” шийдвэр гаргасан байна. Зөвлөлтийнхэн Монголд хятадуудын гар хөл байхыг хүсэхгүй байлаа.

1923 оны намар Монгол Ард Улсын Ерөнхий сайд Б.Цэрэндорж РОСТА агентлагийн сурвалжлагчтай ярилцах үеэрээ Хятадтай харилцах талаар Монголын албан ёсны байр суурийг тайлбарласан байна. Тэр хэлэхдээ: “Одоо бол Монгол автономит засаг болон сюзеренитет системд буцаж орохын тухай ярихын ч хэрэггүй болно. Хамгийн зөв гарц бол Монголыг тусгаар улс гэдгийг л хүлээн зөвшөөрөх явдал юм” (РГАСПИ ф.495, оп.152, д.20, с.143) гэсэн байна.

Монгол Ард улсын Засгийн газраас гадаад бодлогын чиглэлээ 1923 онд батлагдсан “Эдийн засгийн үндсэн бодлого” хэмээх баримт бичигт албан ёсоор тодорхойлсон байдаг билээ. Эдийн засгийн үндсэн бодлого хэмээх баримт бичигт: Монгол Улс Орос, Хятад, Япон, Америк, Англи, Герман улсуудтай юуны өмнө харилцах хүсэл эрмэлзэлтэй болохоо тодорхой тусгажээ. Энэхүү баримт бичигт

нэр дурьдсан улсууд нь 1912 онд Богдын Засгийн газраас харилцаа тогтоох, хамтран ажиллах саналаа илэрхийлсэн дэлхийн есөн улсууд байлаа. Өөрөөр хэлбэл тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан Монгол Улсын гадаад бодлогын ерөнхий чиг хандлага 1910-аад онд хийгээд 1920-иод онд болон хожим ч зөрөхөөргүй байсны илрэл юм.

Дүгнэлт

1921 оны 11 дүгээр сарын 5-ны гэрээ нь Зөвлөлт Орос Монголын хооронд улс төрийн холбоо тогтоосон анхны олон улсын гэрээ болов. Эл хэлэлцээр 1917-1920 оны Октябрийн эргэлт хийгээд бүс нутгийн олон улсын нөхцөл байдлаар Монгол - Оросын уламжлалт хэлхээ холбоог сэргээхэд тодорхой дэмжлэг үзүүлсэн болно. Зөвлөлт Оросын зүгээс Монголыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн явдал нь тус улсад улс төр, эдийн засаг, цэргийн талаар тусгаар тогтносон улс болох нөхцлийг бүрэлдүүлсэн юм. Энэ нь ирээдүйд Хятадаас бүрэн тусгаар тогтнолоо олж, албан ёсоор хүлээн зөвшөөрүүлэхэд хүргэсэн билээ. Харин Зөвлөлтийн хувьд энэ гэрээ нь үзэл суртлын эрх ашгаас (Дорно зүгт үндэсний хувьсгалын хөдөлгөөнийг дэмжих) гадна улсынх нь ашиг сонирхолтой нийцэж байсан болно. Учир нь ах дүүгийн найрамдалт хөрш Монгол орон нь Хятад болоод Японы эсрэг үүсэх мөргөлдөөнд “завсарын бүс” болон Орос улсын аюулгүй байдалд тэдний зүгээс үзүүлэх шууд аюулыг зөөлрүүлэх хаалт болон оршиж байв.

1912-1915 онуудын Орос, Монгол, Хятадын цуврал хэлэлцээрүүдээс ялгаатай нь 1921 оны гэрээгээр Монголыг олон улсын эрх зүй, дипломатын хүрээнд хүлээн зөвшөөрүүлэх үндсийг бүрдүүлээгүй юм. Харин эл асуудлыг Зөвлөлт Хятадын албан ёсны төр улсын харилцаа болоод хувьсгалт үзэл суртлын харьцаанд гарах өөрчлөлтөөс хамааруулан ирээдүйн асуудал болгон үлдээжээ. 1921 оны гэрээ нь хуучин Орос, Монгол, Хятадын гурван улсын гэрээний нэгэн адил “пан монгол”-ын асуудлуудыг шийдвэрлэж чадаагүй болно.

Монгол Ард Улсаас гадаад улстай байгуулсан анхны энэхүү хэлэлцээр нь хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны хамгийн эгзэгтэй үеийн эрх зүйн чухал суурь баримт бичиг болсон бөгөөд үүгээр бүрэн эрхт дипломат болон консулын төлөөлөгчөө харилцан солилцохоор тохирч, дипломат харилцаа тогтоосон нь хоёр улс бие биеийнхээ бүрэн эрхт байдлыг хүлээн зөвшөөрсөн хэрэг хэмээн түүх бичлэгт тэмдэглэж иржээ. Хэлэлцээрийн дагуу хоёр улс дипломат харилцаа тогтоож, 1922 онд Нийслэл Хүрээнд болон Москва хотод Элчин сайдын яамаа харилцан нээсэн нь Монгол Улс Зөвлөлт Орос Улсын харилцааны түүхэнд шинэ үеийг нээсэн юм.

Ашигласан материал

***РГАСПИ - Российский государственный архив
социально-политической истории
УТА - Монгол Улсын Үндэсний төв архив***

1. Батсайхан О. 2005. Монгол үндэстэн бүрэн эрхт улс болох замд (1911-1946), Улаанбаатар.
2. Батсайхан О. 2016. Монголын сүүлчийн эзэн хаан Богд Жавзандамба хутагт: амьдрал ба домог. Соёмбо хэвлэлийн газар. Улаанбаатар.
3. Болд Р. 2008. Монголын тусгаар тогтнол ба АНУ: Монголын тусгаар тогтнолын талаарх АНУ-ын үзэл хандлага, байр суурь, бодлого. 1910-1973. Нэпко. Улаанбаатар.
4. Лузьянин С.Г. 2015. XX зууны эхний хагас дахь Орос, Монгол, Хятад: 1911-1946 оны улс төрийн харилцааны асуудал. Адмон. Улаанбаатар.
5. Магсаржав Н. 1994. Монгол Улсын шинэ түүх. Монгол бичгээс кирилл үсэгт буулгаж хэвлүүлсэн О.Батсайхан, З.Лонжид. Сүхбаатар хэвлэлийн газар. Улаанбаатар.
6. Монгол Ардын Хувьсгалт Намын товч түүх 1-5 дугаар бүлэг. 1964. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар.
7. Монгол Ардын Хувьсгалт Намын товч түүх. Гуравдахь хэвлэл. 1985. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар.
8. Монгол Ардын Хувьсгалт Намын түүхийн зарим чухал баримтууд (1920-1924). 1946. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар.
9. Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэнд холбогдох баримт бичгүүд (1920-1940). Нэгдүгээр дэвтэр. 1966. Улсын Хэвлэлийн хэрэг эрхлэх хороо. Улаанбаатар.
10. Монголын түүх (1911-2017) 2018. О.Батсайхан, З.Лонжид, Ч.Энхбат, С.Баатар, С.Амарсанаа. Соёмбо. Улаанбаатар.
11. Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт. 1920-1932. Баримтын эмхтгэл /Хариуцлагатай эмхтгэгч, С. Дамдинсүрэн, Железняков А.С. ; эмхтгэгч, О. Батсайхан, В.Н. Шепелев. Өнгөт хэвлэл. Улаанбаатар.
12. Монгол Улсын автономи хэмээх өөртөө эзэрхэн засах эрхт засгийн үеийн үнэнхүү явдал чухам байдал, чухал учрыг тэмдэглэсэн товч өгүүлэл хэмээх түүх бичиг. Монгол бичгээс кирилл үсэгт буулгаж хэвлүүлсэн О.Батсайхан. Хоёр дахь хэвлэл. 1992. Засгийн газрын хэвлэл. Улаанбаатар.
13. Монголын түүхэн дэх Барон Р.Ф. фон Унгерн-Штернберг Олон улсын эрдэм шинжилгээний хурлын өгүүллийн эмхэтгэл. 2021. Эмхэтгэгч О.Батсайхан, С.Л.Кузьмин. Битпресс хэвлэлийн газар. Улаанбаатар.
14. Монгол ба Коминтерн. Баримт бичгийн эмхэтгэл, 1996, Улаанбаатар.

15. Монголия в документах из архивов ФСБ России (1921–1936 гг.): сб. док. / науч. ред. В.В.Наумкин, отв. ред.: К.В.Орлова, В.В.Грайворонский; Ин-т востоковедения РАН. 2019. Москва.
16. Навааннамжил Г. 1956. Өвгөн бичээчийн өгүүлэл. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар.
17. Сокобин Монголын тухай 1921-1924. Баримтын эмхтгэл. 2017. Улаанбаатар.
18. Сүхбаатар Д. Түүхийн баримтуудын цоморлиг. 1964. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар.
19. Сүхбаатарын баримт бичгийн эмхтгэл. Эмх. Б.Ширэндэв, 1971. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар.
20. Цэрэндорж Б. Баримт бичгийн эмхэтгэл О.Батсайхан, Х.Магсаржав 1998, Улаанбаатар.
21. Чойбалсангийн зохиолууд, илтгэл, өгүүлэл, хэлсэн үг. 1953. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар.
22. Чойбалсан Х., Лосол Д., Дэмид Г. 1979. Монгол Ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх. Хоёр дахь удаагийн хэвлэл. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар.